

ХААН БАНК ХК-ИЙН 2025 ОНЫ НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТЫН ТАЙЛАН

ХААН Банк ХК ("Банк" гэх) нь Монгол Улсын Компанийн тухай Хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.10 дахь хэсэг, Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.14, Банкны Ногдол ашгийн бодлого болон Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 05 тоот тогтоолын дагуу 2025 оны татварын дараах цэвэр ашгаас энгийн хувьцаа эзэмшигч нарт нэгж хувьцаанд 214 (хоёр зуун арван дөрөв) төгрөг буюу 1,912,198,000 (нэг тэрбум есөн зуун арван хоёр сая нэг зуун ерэн найман мянга) ширхэг хувьцаанд нийт 409,210,372,000 (дөрвөн зуун есөн тэрбум хоёр зуун арван сая гурван зуун далан хоёр мянга) төгрөг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Монголбанкнаас 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр ирүүлсэн А-1/298 тоот ногдол ашиг олгох зөвшөөрлийн дагуу хувьцаа эзэмшигчдэд "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК болон "ХААН Банк" ХК-иар дамжуулан ногдол ашгийг хуваариллаа.

Ногдол ашиг хуваарилалтын дараах байдлаар Банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллаж байна.